

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2024.08.26

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Nvidia компанийн 2-р улирлын тайлан зах зээл дээр өндөр хүлээлтэд байна
- Jerome Powell бодлогын хүүг бууруулахаа бататгалаа
- Ам.долларын ханш буурсаар байна
- АНУ-д ипотекийн зээлийн хүү 6.46% болж буурлаа
- Хятадын төв банк хүүгээ хэвээр үлдээлээ
- Baidu компанийн орлого 2-р улиралд хүлээлтээс бага гарсан ч ашиг нь шинжээчдийн таамгийг давсан

2024 он 8-р сарын 26

Dow Jones	41,175.08
S&P 500	5,634.61
Nasdaq	17,877.79
DAX	18,633.10
FTSE 100	8,327.78
S&P/ASX 200	8,059.80
HANG SENG	17,761.00


АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	1.14%	0.68%	1.44%	9.25%	19.88%	16.13%
S&P 500	1.15%	0.47%	3.21%	18.13%	27.89%	24.95%
Nasdaq	1.47%	0.01%	3.00%	19.10%	31.54%	18.17%
2024 оны 8 сарын 26-ны 11:00						



Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	0.76%	1.15%	1.17%	11.23%	19.20%	17.55%
FTSE 100	0.48%	-0.35%	0.51%	7.69%	13.48%	16.50%
2024 оны 8 сарын 26-ны 11:00						



Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	0.46%	0.99%	1.74%	6.17%	13.27%	7.62%
Hang Seng	0.81%	1.04%	4.29%	4.13%	-1.14%	-30.13%
2024 оны 8 сарын 26-ны 11:00						





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Индексүүд бүх цаг үеийн дээд ханшаа шинэчлэн тогтоох уу?

Аж үйлдвэрийн салбарын компаниуд илүү өсөлттэй байж DJIA индекс 0.68 хувийн өсөлтийг үзүүлж бүх цаг үеийн дээд ханшаа шинэчлэн тогтооход ойрхон байна. S&P 500 болон Nasdaq индексүүдийн хувьд долоо хоногийн төгсгөлд өндөр өсөлтийг үзүүллээ. Индексүүдийн цаашдын өсөлтөд энэ долоо хоногт танилцуулагдах Nvidia компанийн 2-р улирлын тайлан нөлөөлөхүйц байна. Хэрэв хүлээлтээс сайн гарч технологийн өсөлт цаашид үргэлжлэх нь тодорхой болбол индексүүд бүх цаг үеийн дээд ханшаа эвдэхэд ойрхон байна.

Jerome Powell бодлогын хүүг бууруулахаа бататгалаа

Өнгөрсөн долоо хоногт хамгийн анхаарал татсан үйл явдал нь Jackson Hole-д болсон эдийн засгийн уулзалтад Powell хэлэхдээ "Хүү бууруулах цаг нь болсон" гэж хэлсэн юм. Энэ нь 9-р сард хүүг бууруулах нь баттай болсныг итгэж байгаа бөгөөд 25 суурь нэгжээр бус 50 суурь нэгжээр бууруулах боломжтой болохыг мэдэгдээд байна.

Ам.долларын ханш буурч, зах зээлийн хүлээлт өөрчлөгдлөө

АНУ-ын долларын ханш огцом буурч, Долларын индекс (DXY) 102-оос доошилж, өнгөрсөн оны 12-р сараас хойших хамгийн бага түвшинд хүрлээ. Энэ нь ХНС-ын хүүгийн бодлого болон АНУ-ын эдийн засгийн хэтийн төлөвтэй холбоотой зах зээлийн хүлээлт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй бөгөөд инфляцын бууралт болон хөдөлмөрийн зах зээл буурч байгаагийн дохио нь энэхүү уналтыг өдөөж байна.

Ипотекийн зээлийн хүү буурч байна

Эдийн засаг сулар нь гэсэн хүлээлт болон ХНС-аас хүүг бууруулах хүлээлт нь 30 жилийн хугацаатай тогтмол хүүтэй зээлийн дундаж хүүг 6.46% болгож бууруулжээ. Уг хүү нь 2023 оны 10-р сард 7.79 хувьд хүрэн дээд цэгээ тогтоогоод байсан юм. Хүү буурахтай зэрэгцэн орон сууцны борлуулалт баг зэргээр нэмэгдсэн . ХНС-аас ирэх 9-р сард хүүгээ бууруулна гэсэн хүлээлт орон сууцны зах зээлийг идэвхжүүлж байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

БНХАУ-ын хувьцаанууд өнгөрсөн долоо хоногт уналт үзүүлээ

Хятадын хувьцаанууд өнгөрсөн долоо хоногт уналттай хаагдлаа. Үүний шалтгаан нь БНХАУ-д зарлагдах эдийн засгийн мэдээлэл багатай байснаас гадна, АНУ-ын Холбооны Нөөцийн банкны дарга Пауэлл Jackson Hole уулзалтаар юу ярих эсэх талаар хүлээлт байлаа. Шанхайн болон CSI 300 индексүүд буурсан бол Хонгконгийн Hang Seng индекс өнгөрсөн долоо хоногт өсөлт үзүүлжээ.

Хятадын төв банк хүүгээ хэвээр үлдээж банкнуудын ашигт ажиллагааг хамгааллаа

Даваа гарагт Хятадын төв банк зээлийн хүүгээ өөрчлөлгүй үлдээсэн байна. Нэг жилийн зээлийн хүү 3.35%, таван жилийн зээлийн хүү 3.85% хэвээр үлдлээ. Энэ нь банкнуудын ашгийг хамгаалах гэсэн бодлого юм. Эдийн засагчид хүү өөрчлөгдөхгүй гэж таамаглаж байсан учир энэ нь тэдний хүлээлттэй нийцсэн тул зах зээлд өндөр хэлбэлзлийг үзүүлсэнгүй. Гэхдээ ирэх саруудад Хятадын төв банк хүүгээ дахин бууруулж магадгүй гэж эдийн засагчид үзэж байна.

BAIDU компанийн ашиг хүлээлтийг давлаа

Санхүүгийн тайланд, Baidu компанийн орлого хоёрдугаар улиралд хүлээлтээс бага гарсан ч ашиг нь шинжээчдийн таамгийг давсан байна. Baidu-ийн орлого 0.4%-иар буурч, 33.9 тэрбум юань болсон гэж мэдээллээ.

График 2: BAIDU компанийн хувьцааны ханш

abliguun published on TradingView.com, Aug 26, 2024 11:09 UTC+8



TradingView

BAIDU нь Хятадад AI салбарын тэргүүлэгч бөгөөд түүний Ernie AI модель нь технологийн дэвшилтэт шийдлүүдийг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн Baidu-ийн Apollo платформ нь автономит жолоодлогын салбарт томоохон байр суурь эзэлж байгаа. Хятадын зах зээлд автономит тээврийн хэрэгсэл, ухаалаг хотуудын шийдлүүд өсөн нэмэгдэж байгаа учир энэ технологи ирээдүйд ихээхэн үнэ цэнтэй байх төлөвтэй байна. Гэвч хувьцааны ханш нь түүхэн дээд ханшаасаа 4.1 дахин унасан байна.

ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS W WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning August 19, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
ZIM	paloalto	LOWE'S	Toll Brothers	TARGET	snowflake	Baidu	CAVA	GF			
ESTÉE LAUDER COMPANIES (CSCO)	fabrinet	Medtronic	DADA	macy's	zoom	CSJ SYSTEMS, INC.	workday	CHRYSLER FINANCIAL GROUP	HAFNIA		
FREIGHTOS	BIT DIGITAL	WORKHORSE	COTY	TJX	WOLF	PELTON	Bill.com				
	agora	NISSAN	jack henry	ANALOG DEVICES	WOLFspeed	AAP	intuit				
	AMERICAN RECOVERIES CORPORATION	NANOX	LABOY	DYCOM	Agilent Technologies	BI's	ROSS DRESS FOR LESS				
	FLUENT	唯品会 vip.com	KEYSIGHT TECHNOLOGIES	ZEEKR	URBAN OUTFITTERS	WILLIAMS-SONOMA	Red Robin				
	FLEX	XPEV	SOM	YUM	NCSN	NES	Macro				
	FLUENT	X P E N G	ZIO	清和 Full Truck Alliance	Nordson	NotEase Games	AMERICAN SOFTWARE				
	HESAI	FUTU	ZTO 中通快递	Chemomab	mdxhealth	CanadianSolar					
	E.C.D. AUTOMOTIVE DESIGN	Kingsoft Cloud	emeren	GDS 万国数据	LUFAX	TD Bank					
		华住 WORLD	PagSeguro			bilibili					
http://eps.sh/cal										© 2024 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning August 26, 2024									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close		
PDD	TCCOM	BNS	S	ARF	NVDA	BEST BUY	DELL	FRD			
Pinduoduo Inc. 拼多多	Trip.com	Scotiabank	SentinelOne	Abercrombie & Fitch	nvidia	DOLLAR GENERAL	lululemon	FRONTLINE			
DG	HEICO	BMO	box	chewy	CROWDSTRIKE	AMERICAN EAGLE OUTFITTERS	ULTA	Jinko			
DADO NEW ENERGY	tuya	allot	PVH	理想	salesforce	BURLINGTON	MARVELL	MINI			
VIOMI	Woodmark	scansource	INCINO	KOHL'S	affirm	OLLIE'S	Gap Inc.	SOLO			
	BHP	Energy	NORDSTROM	Foot Locker	okta	Campbell's	AUTODESK				
		AMBA	Ambarella	Bath & Body Works	PURESTORAGE	BIRKENSTOCK	mongoDB				
		HAIR	SEMTECH	Donalson	VEEVA	Polestar	3D SYSTEMS				
		HEIL	Ooma	RBC	five BELOW	stratasys	elastic				
		海底捞 Haidilao	世纪互联 VNET	I-MAB	hp	DOMO					
		CADELER	Joyy	Global Blue	NetApp						
		亿华能源 CNHI									
http://eps.sh/cal										© 2024 Earnings Whispers	